


БАТЛАВ.
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ОЛБОРЛОХ
 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
 ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ



**ХЭНТИЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа	Санхүүжилтын эх үүсвэр /мян.төг/	Хариуцах эзэн	Хамтрах талууд
1	Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд				
1.1	Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох газруудад хүргүүлэх, төлөвлөгөөний дагуух хэрэгжилтийн тайланг гаргуулах, нэгтгэн дүгнэх	2, 4 дүгээр улирал	-	ХБТХОХ	Дэд зөвлөлийн гишүүн байгууллагууд
1.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргаж дэд зөвлөлийн гишүүд, холбогдох сумдад хүргүүлэх	Улирал бүр	-	ХБТХОХ	БОАЖГ
1.3	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээг гаргаж баталгаажуулан ОУИТБС-ын ажлын албанд цахимаар болон бичгээр хүргүүлэх	2 дугаар улиралд	-	СТСХ	ХБТХОХ, Татварын хэлтэс, сумдын ЗДТГ
1.4	Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх мэдээ, тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргах	1 дүгээр улиралд	-	БОАЖГ	Сумдын ЗДТГ
1.5	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аймаг, сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээ, гэрээний хэрэгжилтийг ОУИТБС болон холбогдох байгууллагад хүргүүлэх	2, 4 дүгээр улиралд	-	ХБТХОХ	Сумдын ЗДТГ
1.6	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтын ажил зохион байгуулах	3 дугаар улиралд	БХНСЗ 1500,0	АЗДТГ	МХГ, ЦГ, БОАЖГ, ОБГ, ХХУГ, ТХ, СГЗ, ГИХГ, Сумдын ЗДТГ
2	Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд				

2.1	Аймгийн http://khentii.gov.mn цахим хуудасны тусгай зөвшөөрөл цэсэнд мэдээлэл тогтмол оруулах, хариуцлагатай уул уурхайн хүрээнд хийж буй арга хэмжээ, ажил үйлчилгээг олон нийтэд нээлттэй, ил тод сурталчлах	Улирал бүр	-	АЗДТГ	БОАЖГ, Сумдын ЗДТГ
2.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагааны тайлан, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй арга хэмжээ, ажил үйлчилгээг тухайн орон нутгийн багийн иргэдийн нийтийн хурал, сумын ИТХ-д хэлэлцүүлж, олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнах ажлыг хэвшүүлэх	Жилийн турш	-	Сумын ЗДТГ	Багийн Засаг дарга нар, ААН-үүд
3	Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд				
3.1	Аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах, чадваржуулах сургалт, зөвлөгөөнд дэд зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн төлөөллийг хамруулах	Тухай бүр	-	Аймгийн дэд зөвлөл	Холбогдох байгууллагууд
3.2	Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр албан уулзалт зохион байгуулах	2, 4 дүгээр улиралд	-	Аймгийн дэд зөвлөл	Салбарын төрийн байгууллагууд
3.3	Төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах	Жилдээ	ОУИТБСЗ 1000,0; ОНТ 2000,0	Аймгийн дэд зөвлөл	Холбогдох байгууллагууд

АЙМГИЙН ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛ